

## АГУУЛГА

### Тайланг бэлтгэсэн:

Булган аймаг дахь

Төрийн Аудитын газар

Тэргүүлэх Аудитор

Д.Анхбаяр

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Гэрээт ажилтан

З.Ганбаатар

2018 оны 5 дугаар сар

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зййл байвал 70342495 дугаарын утас, дугаарын факсаар харилцана уу.

Хаяг: Булган сум 5-р баг  
Нуггийн удирдлагын ордон  
өрөө № 401 тоот  
Bulgan@audit.gov.mn

## Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

### **Бүлэг I**

1.1. Дэвшүүлсэн зорилт болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үндсэн үүрэг, төлөвлөгөөт ажил үйлчилгээг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.2 Байгууллагын бүтэц, орон тоог баталсан журмыг дагаж мөрдөөгүй байна.

### **Бүлэг II**

2017 оны санхүүгийн үйл ажиллагаа үр дүнтэй, арвилан хэмнэлттэй, ашигтай зарцуулсанг, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан байна.

### **Бүлэг III**

2017 оны санхүүгийн үйл ажиллагаа үр дүнтэй, арвилан хэмнэлттэй, зарцуулсан байна.

Дүгнэлт, зөвлөж.....9-10

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

НА

БОЯБХ

БОАЖГ

Нийцлийн аудит

Биологийн олон янз байдлыг хамгаалах

Байгаль орчин аялал жуулчлалын газар

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2018.04.30

Булган

### 1. Аудитын нэр:

Гол усны сав газар болон тусгай хамгаалалттай газруудад хэрэгжиж байгаа хууль, журмын хэрэгжилтийн үр дүн.

### 2. Аудитын код:

БУА-2018-02-НА

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Булган аймаг дахь Төрийн Аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### 4. Аудитын зорилт:

Гол усны сав газар болон тусгай хамгаалалттай газруудад хэрэгжиж байгаа хууль, журмын хэрэгжилтийн үр дүнд нийцлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгднэ.

### 5. Аудитын хамрах хүрээ:

Булган аймгийн Зэд-Хантай-Бүтээлийн нурууны ДЦГ-ын хамгаалалтын захиргаа, Хөгнө тарна байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Хануй голын сав газрын захиргааны 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох судалгаа, нотлох баримт, бусад тусгай сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл тус тус хамрагдлаа.

### 6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 10-100, 4000, 4100 дугаар стандартууд болон, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт, материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, зарим арга хэмжээнээс түүвэрлэн шалгах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндсэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### 7. Аудитад ашиглагдах хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, холбогдох бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль ,
- Төрийн аудитын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчин бүсийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Усны тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- “Ус үндэсний хөтөлбөр”
- Холбогдох бусад хууль, эрх зүйн акт, тушаал, шийдвэр

#### 8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, гэрээт ажилтан З.Ганбаатар нар хөтөлбөрт заасан хуваарийн дагуу 2017 оны 05 дугаар сарын 01-нээс 06 сарын 30-ны хооронд ажлын 10 хоногт хийж гүйцэтглээ.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

Байгууллагын бүтэц, орон тоог баталсан журмыг дагаж мөрдөөгүй байна.

### Бүлэг 1

Байгууллагын жилийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 1.1. Дэвшүүлсэн зорилт болон үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үндсэн үүрэг, төлөвлөгөөт ажил үйлчилгээ:

Хамгаалалтын захиргааны 2017 оны ажлын төлөвлөгөөг менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулж 65 ажил үйлчилгээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ТХНУГ-ын даргаар батлуулсан.

Тухайн онд нийт 65 ажил хийхээр төлөвлөсний 60 ажил үйлчилгээг хэрэгжүүлж ажилласан байна.

Дархан цаазат газарт газар нутгаараа хамаарагддаг гурван сумын Засаг дарга нартай 2017онд хамтран ажиллах гэрээ байгуулж тус бүр 14-17 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж ажлын хэрэгжилт жилийн эцэст Тэшиг сум 12, Сэлэнгэ сум 13, Хутаг-Өндөр 13 ажил үйлчилгээ бүрэн хийгдсэн .

Гэрээний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Сумын нэрс	Ажил үйлчилгээ	Огт хэрэгжээгүй	Бүрэн хэрэгжсэн
Тэшиг	14	2	12
Сэлэнгэ	15	2	13
Хутаг-Өндөр	17	4	13
Нийт	46	8	38

Хүснэгтээс үзэхэд 3 сумын нийт 46 ажил хэрэгжихээс 38 ажил бүрэн хэрэгжсэн 8 ажил үйлчилгээ огт хэрэгжээгүй. Энэ нь тайланд онд ой хээрийн түймэр гарсантай холбоотойгоор ажилах хүч дутсантай холбоотой байна.

2017 онд "Нэгдмэл нэг санаа зорилгын" уриан дор 30 бүтээлч ажил хийхээр төлөвлөн Хилийн цэргийн 0286 дугаар ангитай хамтран ажиллаж төлөвлөгөөт 30 ажлаас 26 ажил үйлчилгээ бүрэн хэрэгжиж 4 ажил үйлчилгээг огт хэрэгжээгүй гэж тусгажээ.

## 1.2 Байгууллагын бүтэц, орон тоог баталсан журмыг дагаж мөрдөөгүй байна:

Зэд-Хантай-Бүтээлийн нуруу дархан цаазат газар нь 2017 онд 18 үндсэн ажилтан 8 гэрээт ажилтан нийт 26 хүний орон тоо баталсан, захиргааны дарга, 4 мэргэжилтэн, 9 байгаль хамгаалагч, 4 үйлчилгээний ажилтан, 5 гэрээт байгаль хамгаалагч, 4 гэрээт ажилтныг ажиллуулж 1 хүнийг илүү орон тоотой ажиллаж байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоол "Байгаль орчин аялал жуулчлалын сайд"-ын А/233 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

2017 оны санхүүгийн үйл ажиллагаа үр дүнтэй, арвилан хэмнэлттэй, ашигтай зарцуулсанг, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан байна.

## Бүлэг 2

Төлөвлөгөөгөөр баталсан төсвийг 15.682.2 мянган төгрөгийн хэмнэж ажилласан байна.

2.1. Зэд-Хантай-Бүтээлийн нуруу дархан цаазат газрын захиргаа нь тайлант онд Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас орлогыг 3.0 сая төгрөг гэж төлөвлөн баталсан бол гүйцэтгэлээр 5.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлого болгож оруулсан бөгөөд орлогыг 2.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

мянган/төг

Огноо	Овог нэр	Орлогын төрөл	Мөнгөн дүн
2017.01.09	Г.Хандсүрэн	Нэвтрэх хураамж	75.0
2017.01.17	Б.Ширзаан	Торгүүлийн төлбөр	50.0
2017.01.17	Д.Билгээ	Торгүүлийн төлбөр	50.0

2017.01.17	О.Отгончулуун	Торгүүлийн төлбөр	1.200.0
2017.01.30	Г.Хандсүрэн	Торгүүлийн төлбөр	45.0
2017.03.22	Ц.Ганбаатар	Торгүүлийн төлбөр	1.200.0
2017.02.27	Ц.Баярмаа	Торгүүлийн төлбөр	30.0
2017.05.03	Б.Ган-Эрдэнэ	Торгүүлийн төлбөр	100.0
2017.05.04	Г.Бат-Эрдэнэ	Торгүүлийн төлбөр	160.0
2017.05.09	М.Амарбаяр	Нэвтрэх хураамж	30.0
2017.05.09	Г.Хандсүрэн	Нэвтрэх хураамж	45.0
2017.05.18	Б.Батбилэг	Торгүүлийн төлбөр	480.0
2017.05.22	Ц.Төмөртоого	Нэвтрэх хураамж	15.0
2017.05.31	Г.Бат-Эрдэнэ	Нэвтрэх хураамж	45.0
2017.06.27	Д.Баяраа	Торгүүлийн төлбөр	240.0
2017.06.27	Ц.Төмөртоого	Нэвтрэх хураамж	75.0
2017.07.28	Л.Лхагвадорж	Торгүүлийн төлбөр	80.0
2017.08.10	Н.Минжмаа	Торгүүлийн төлбөр	60.0
2017.08.10	У.Батмэнд	Торгүүлийн төлбөр	136.0
2017.08.10	Н.Ундрах	Торгүүлийн төлбөр	70.0
2017.08.10	О.Батжаргал	Нэвтрэх хураамж	300.0
2017.12.31	Б.Батбаяр	Нэвтрэх хураамж	7.5
2017.12.31	Ц.Баярмаа	Нэвтрэх хураамж	653.0
Нийт			5146500

Хүснэгтээс үзэхэд торгуулийн төлбөр 3901.0, нэвтрэх хураамж 1245.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Зэд-Хантай-Бүтээлийн нуруу дархан цаазат газар нь 2017 оны төсвийг 228991.3 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 213.309.1 мянган төгрөгийг зарцуулж, байгаль орчин аялал зуучлалын яаманд 17828.5 мянган төгрөгийг төвлөрүүлж 15.682.2 мянган төгрөгийг хэмнэж ажиллажээ.

Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Анх батлагдсан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	цалин хөлс	173272.9	173272.9	159658.1	13614.8
2	Нийгмийн даатгалын шимтгэл	19060.0	19,060.0	18,210.7	849.3
3	Гэрэл цахилгааны зардал	341.5	341.5	341.5	-
4	Түлш халаалтын зардал	3564.0	3564.0	3531.0	33.0
5	Цэвэр, бохир ус	712.8	712.8	712.0	0.8

6	Зөөлөн эдлэл нормын хувцас худалдан авах зардал	269.3	269.3	269.3	-
7	Бичиг хэргийн материал	558.8	558.8	558.8	-
8	Тээвэр, шатахууны зардал	2945.2	2945.2	2945.2	-
9	Шуудан холбооны зардал	527.1	527.1	490.1	37.0
10	Багаж хэрэгсэл	302.9	302.9	302.9	-
11	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1425.6	1425.6	1425.6	-
12	Дотоод томилолтын зардал	1293.8	1293.8	1293.8	-
13	Гадаад томилолт				-
14	Бусдаар гүйцэтгүүлсэн	18383.3	18383.3	17236.0	1147.3
15	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	934.1	934.1	934.1	-
16	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал /300.0/	5400.0	5400.0	5400.0	-
	Нийт зардал	<b>228.991.3</b>	<b>228.991.3</b>	<b>213.309.1</b>	<b>15.682.2</b>
	Төвлөрүүлэх			<b>17828.5</b>	

Тайлант онд тододголоор өөрчлөлт оруулаагүй байна. Төсвийн гүйцэтгэлээс тайлант онд цалингийн зардал 13614.8, нийгмийн даатгалын шимтгэл 800.0, бусдаар гүйцэтгүүлсэн зардал 1147.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй ажилласан байна.

**2.2** Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар нь “Биологийн олон янз байдлыг хамгаалах” төслөөс 185 сая төгрөгийн нийт 48 нэр төрлийн бараа материал авч үндсэн хөрөнгийн данс бүртгэлд бүрэн тусгаж ажиллажээ.

Байгууллагын дотоод ажил үйлчилгээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийг хүснэгтээр харуулбал:

№	Тээвэрийн хэрэгслийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо	Үнийн дүн
1	УАЗ 3309	2017	1	38.500.000.00

2	Ландкрузер-76	2017	1	93.151.943.50
3	УАЗ-469	2014	1	18.000.000.00
4	Мотоцикль-Шарк 200	2014	14	23.688.000.00
5	Мотоцикль-YAMAHA VBR 125G	2013	2	3.960.000.00
	<b>Нийт</b>		<b>19</b>	<b>177.299.943.50</b>

Хүснэгтээс үзэхэд Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар нь 2017 онд “Биологийн олон янз байдлыг хамгаалах” төслөөс Ланд крузер-76, УАЗ машиныг үнэ төлбөргүй авсан. Нийт байгаль хамгааллын 13 пост үйл ажиллагаа явуулдаг бүх постыг мотоциклоор хангасан байна.

#### **Нэмэлт санхүүжилт:**

Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын нэмэлт санхүүжилтийн дансаар албан томилолт, шатахуун, малын тэжээл хужир зэрэгт 9716.7 мянган төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон мөнгөний зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хаанаас	Орлого	Бичиг хэрэг	Албан томилолт	Шатахуун	Малын тэжээл	ХХОАТ	Зардал
Булган Засаг дарга	1000.0		348.5				348.5
“БОЯБХ” төсөл	4166.7		96.0				96.0
			73.0				73.0
БОАЖГазар	3500.0			2000.0			2000.0
БОАЖГазар	1050.0	1500.0					1500.0
			793.5				793.5
				355.6			355.6
					2640.0		2640.0
					860.0		860.0
						90.0	90.0
				141600			141600
					810.0		810.0
<b>Нийт</b>	<b>9716.7</b>	<b>1500.0</b>	<b>1311.0</b>	<b>2497.2</b>	<b>4310.0</b>	<b>90.0</b>	<b>9708.2</b>



Тайлант онд 9716.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалт нь бичиг хэрэгт 1500.0, албан томилолтод 1311.0, шатахуунд 2497.2, малын тэжээл, хужирт 4310.0, орлогын албан татварт 90.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж нийт 9708.2 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр 8.5 мянган төгрөгийн хэмнэж ажиллажээ.

Булган аймаг дахь Төрийн  
аудитын газар

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хэр үр дүнтэй байна  
вэ?

### Бүлэг 3

Шилэн дансны мэдэллийг байршуулахдаа журамыг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

**3.1.** Байгууллагын шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбар нь журамд заасан шаардлагыг хангасан уу?

Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөх хуулийн заалт гарсан бөгөөд тус байгууллага нь хуулийн дагуу санхүүгийн талаарх мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) вэйб сайтад санхүүгийн төсөв гүйцэтгэл, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хоцроосон, даргын гарын үсэггүй мэдээлэл оруулсан, зэрэг шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх гэж заасныг, 7.1.1-т даргын гарын үсгээр баталгаажсан байна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Цаашид шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж санхүүгийн мэдээллийг цаг хугацаанд нь тавьж, иргэд олон нийтэд ил тод нээлттэй байхад анхаарч, ажлыг сайжруулах шаардлагатай байна.

#### Дүгнэлт:

Аудитаар “Биологийн олон янз байдлыг хамгаалах” төслөөс олгосон бараа материалыг нярав, нягтлан бодогч нар бүрэн орлогдож авсан байна.

❖ Тайлант онд төлөвлөсөн ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэж ажиллах шаардлагатай,

❖ Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар нь батлагдсан орон хэтрүүлсэн ,

❖ Шилэн дансны тухай хуулийн зарим заалтын дагуу мэдээллийг хугацаа хоцроосон, удирдах албан тушаалтны гарын үсэггүй мэдээлэл оруулсан, зэрэг зөрчил дутагдал илэрсэн тул дотоод хяналтыг сайжруулж ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

**Зөвлөмж:**

Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын дарга  
Д.Болорчулуун, нягтлан бодогч Д.Жаргалмаа нарт.

1.Байгууллагын орон тоог баталсан хэмжээнээд багтааж ажиллах.

2.Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон байгууллагын дотоод хяналтыг сайжруулаж ажиллахыг зөвлөж байна.

**Мэдэгдэл:**

Аудитад хамрагдсан санхүүгийн баримт, холбогдох тоо материалд тулгуурлан нотлох баримтыг ханган дээрх аудитын тайлангийн төслийг боловсрууллаа.

Аудитаар илэрсэн зөрчил,дутагдалд дүгнэлт хийн засаж залруулан арилгах зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор хариу ирүүлэхийг мэдэгдье.

**ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

**ТАЙЛАН БИЧСЭН:**

АУДИТОР/ГЭРЭЭ Т АЖИЛТАН/

З.ГАНБААТАР